



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН  
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 01 сарын 04 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

НЭГДҮГЭЭР ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Улсын онцгой комиссын хурлыг 2021 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 11:00 цагт Төрийн ордон дахь "Нутгийн удирдлага"-ын танхимд 80 хувийн ирцтэй цахимаар хуралдуулав.

Хурлыг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга Я.Содбаатар даргалж, холбогдох шийдвэрийг гаргаж, үүрэг даалгавар өгөв.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

1. Коронавируст халдвар /Ковид19/-ын нөхцөл байдлын мэдээлэл;

*Эрүүл мэндийн сайд,  
Улсын онцгой комиссын гишүүн Т.Мөнхсайхан,*

2. Нийслэлийн хэмжээнд бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн хугацаанд хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх мэдээлэл;

*Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч,  
Улсын онцгой комиссын гишүүн Д.Сумъяабазар,*

3. Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн хугацааг сунгах тухай;

*Улсын онцгой комиссын орлогч дарга,  
Онцгой байдлын ерөнхий газрын дарга,  
бригадын генерал Г.Ариунбуян,*

4. Бусад

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга,  
Улсын онцгой комиссын гишүүн Б.Ганбат,

Улсын онцгой комиссын орлогч дарга,  
Онцгой байдлын ерөнхий газрын дарга,  
бригадын генерал Г.Ариунбуян

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч,  
Улсын онцгой комиссын гишүүн Д.Сумъяабазар нарт:

1.1. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахалтай тэмцэх, хариу арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор Нийслэлийн хэмжээнд тогтоосон Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, иргэн, хуулийн этгээдийг гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн хугацааг 2021 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 06:00 цагаас 2021 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 06:00 цаг хүртэл хугацаагаар сунгах;

1.2. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор XVII жарны цагаагчин үхэр жилийн Цагаан сарын баярыг улсын хэмжээнд нийтээр тэмдэглэхгүй байх тухай Засгийн газрын тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэх;

Хоёр.Эрүүл мэндийн сайд,

Улсын онцгой комиссын гишүүн Т.Мөнхсайханд:

2.1. Эрүүл мэндийн байгууллага, лаборатори, эмнэлгийн халдвар хамгааллын бэлэн байдлыг хангах чиглэлээр эрсдэлийн үнэлгээ хийж, үнэлгээнд суурилсан эрсдэлийг бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх, эмнэлгийн дотоод халдвараас сэргийлэх, бэлэн байдлыг хангах;

2.2. Коронавируст халдвар /КОВИД-19/-ыг эрт илрүүлэх тандалтыг зохион байгуулах, эмнэлгээр үйлчлүүлж буй хүн бүрт харуулдан тандалт хийх;

Гурав. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч,  
Улсын онцгой комиссын гишүүн Д.Сумъяабазарт:

3.1. Нийслэлийн нутаг дэвсгэрт хэсэгчилсэн байдлаар тогтоосон "Бүх нийтийн бэлэн байдлын зэрэг"-т шилжүүлсэн хугацаанд эрсдэлт бүлгийн хүн амыг тандалт судалгаа, шинжилгээнд бүрэн хамруулах, хөл хорионы дэглэмийг чангатгах, коронавируст халдварын шинжилгээний цэгийн тоог нэмэгдүүлэх;

Дөрөв. Аймаг, нийслэлийн Онцгой комиссын дарга нарт:

4.1. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын тархалт буурахгүй байгаатай холбогдуулан цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, эрсдэлийг бууруулах, халдвар хамгааллын дэглэмийг сахиулах арга хэмжээг бүх түвшинд чангатгах;

4.2. Аймаг, нийслэл, сум хооронд зорчих иргэд, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний хяналтыг сайжруулах, халдвар хамгааллын болон хорио цээрийн дэглэмийг чанд сахиулж, холбогдох арга хэмжээг шуурхай зохион байгуулах;

4.3. Гамшгаас хамгаалах бүх шатны төлөвлөгөөг тодотгон, ажилтан, албан хаагч бүрийг томилгоожуулж, ажил үүргийн хуваарийг баталж, ажлын сахилга бат үүрэг хариуцлагыг өндөржүүлэх;

4.4. Аймаг, орон нутагт коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахалтай тэмцэх шуурхай багийг чадавхжуулах сургалт зохион байгуулж, салбар хоорондын зөвлөх багийг бэлтгэн томилон ажиллуулах;


4.5. Аймгууд коронавируст халдвар /КОВИД-19/-ын зөвөрлөгдсөн тохиолдол бүртгэгдэхээс сэргийлэх, бүх байгууллагуудад шинж тэмдгийн тандалтыг тогтмол хийх, эрсдэлт бүлэг, албан байгууллага, үйлчилгээний газруудын ажилтнуудад идэвхтэй тацдалт, судалгаа хийх;

ДАРГА



Я.СОДБААТАР

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА,  
ДЭД ХУРАНДАА



Т.МӨНХДОРЖ